

БАТЛАВ

ЗАХИРАЛ: Ж.ОЛГОРМАА

5 ДУГААР СУРГУУЛИЙН **“НИЙГЭМ СУДАЛ”** ХИЧЭЭЛИЙН 10-Р АНГИЙН АНГИ  
ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ЖИШИГ ДААЛГАВАР

Анги .....Нэр ..... А хувилбар

1-Р ХЭСЭГ ДААЛГАВАР

1. .... нь хүн амын болон соёлын нөхөн үйлдвэрлэлээрээ өөрийн залгамж, тогтвортой чанарыг хангадаг, нэг нутаг дэвсгэр дээр амьдардаг, өөрийн зохион байгуулалт, эмх цэгц бүхий, улс төрийн хувьд биеэ даасан, өөрсдийгөө тухайн нийгэмд харьяалуулдаг хүмүүсийн тогтвортой нэгдэл юм.

A. Нийгэм                      B. Бүлэг                      C. Нийгмийн харилцаа                      D. Нийгмийн бүтэц  
2. Нийгмийн институтийн чиг үүргийг судална гэдэг нь түүний гүйцэтгэж буй үүрэг буюу үйлдлийн үр дүнд ямар үр дагавар бий болов гэдгийг судлах хэрэг гэж уг онолын гол төлөөлөгч үзжээ.

A. Э.Дюркгейм                      B. К.Маркс                      C. Ж.Г.Мид                      D. Р.Мертон

3. Е. Л.Толстой Хүйс үндэс угсаа зэрэг байр суурь нь:

A.Төрөлх                      B.Олдмол                      C.Мастер                      D.Үндсэн

4. 58. Хүүхэд нийгэмшилтийн аль агентийн нөлөөгөөр “Бие даасан шийдвэр гаргах чадварт суралцдаг” вэ?

A. Гэр бүл                      B. Сургууль                      C. Ажлын байр                      D.Үе тэнгийнхэн

E. Хэвлэл мэдээлэл

Соёл :

5. Уран шувуу модны хөвөнцөр, малын хялгас зэргийг цуглуулаад үүрээ барьдаг ажээ. Энэ нь соёл мөн үү.

A. Уран гоё хийцтэй учир соёл мөн  
B. Шувууны үүр нь өөрөө материаллаг соёл мөн  
C. Бүх амьтдад соёл байдаг болохоор соёл мөн  
D. Уран шувуу үүрээ улам сайжруулж, тайлбарлаж чадахгүй учраас соёл биш  
E. Уран шувуу л амьтдаас ганцаараа соёлтой амьтан

6. Соёл гэдэг нь латин хэлний culture \colere\ гэх ..... , ..... гэсэн утга илэрхийлдэг.

A.Соёолуулан боловсруулах, хөрс боловсруулах  
B. Харилцаа, чадвар                      C. Уламжлал, даяаршил  
D. Хүндэтгэл, хариуцлага                      E. Эзэмшигч, хэрэглэгч

7. Домог мэдлэгийг хэрхэн бүтээдэг вэ?

A.Уран сайхны дүрээр дамжуулан мэдлэг бүтээдэг.  
B.Бурханы бүтээгч хүчийг ашиглан мэдлэг бүтээдэг  
C.Бодит байдлын өөрийнх нь хөгжилд тулгуурлан мэдлэг бүтээдэг  
D.Ид шидийн төсөөлөл дээр тулгуурлаж мэдлэг бүтээдэг                      E. Дээрх бүгд

8. Судлаачдын тэмдэглэснээр “Шашны сүсэг бишрэлийн энгийн хэлбэрүүдийг хэдэн мянган жил оршин тогтносон” гэж үздэг вэ?

A. 10 мянган жил      B.20 мянган      C.30 мянган жил      D.40 мянган жил      E.60 мянган жил

Эрх зүй

9. Human dignity гэдэг утгыг олоорой.

A.Хүний нэр төр      B.Хүний үнэт зүйл      C.Хүний эрхэм чанар      D.Хүний эрх      E.Иргэний эрх

10. Хүний эрхэм чанар хэмээх ойлголтыг олно уу.

A.Хүн бүр хүмүүн болохынхоо хувьд адил үнэ цэнэтэй                      B.Үндсэн эрх эрх чөлөөг эдлэх

- C.Иргэний үндсэн үүргээ биелүүлэх                      D.Иргэн бүрийн өмчийг хамгаалах                      E. А ба В
11. Анх болуудыг чөлөөлсөн бүх хүмүүс ижил эрхтэй гэдгийг тунхаглан шавар бортого дээр бичиж үлдээсэн хүн хэн бэ?
- A.Софистууд                      B.Мартин Лютер Кинг                      C. Э.РРузвельт                      D.Аугаа Сирус
12. Иргэний эрх зүйн харилцааны объект ..... болон ..... багтана.
- A.Оюуны баялаг, Материаллаг баялаг                      B. Мөнгөн баялаг, Мөнгөн бус баялаг
- C. Эдийн баялаг, Эдийн бус баялаг                      D. Эрх зүйн чадамж, Эрх зүйн чадвар
- E. Төрөлх, Олдмол статус
13. 6.7-14 насны хүүхэд эрх зүйн аль чадамжид хамаарах вэ?
- A.Эрх зүйн бүрэн чадамжтай                      B.Эрх зүйн бүрэн бус чадамжтай
- C.Эрх зүйн заримдаг чадамжтай                      D.Эх зүйн чадамжтай
14. Контракт гэрээг ямар тохиолдолд байгуулах вэ?
- A.Ажилтны нийгмийн нөхцөл байдлыг хангах
- B.Ажилтныг хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх нөхцөлд байгуулах
- C.Ажил эрхлэлтийн жилээс хамаарч                      D.Ажилтны насны онцлогоос шалтгаалж
- E.Ажилтны онцгой авьас чадварыг ашиглах нөхцөлд байгуулах
15. ДНБ-ийг зардлаар тооцох үзүүлэлтэд хамаарагдахгүй өгөгдлийг тэмдэглэнэ үү.
- A. Өрх гэрийн хэрэглээний зардал                      B. Аж ахуйн нэгжийн зардал
- C.Төрийн зардал                      D.Татварын зардал
16. Эдийн засгийн хямралаас үүдэн бий болж, хэрэгцээт баялаг үйлдвэрлэн бүтээхэд ихээхэн саад болдог ажилгүйдлийн хэлбэрийг тэмдэглэнэ үү.
- A. Мөчлөгийн                      B. Бүтцийн                      C. Шилжилтийн                      D. Улирлын
17. Эдийн засгийн үндсэн асуудлыг нэрлэнэ үү?
- A. Хязгааргүй хэрэгцээг хязгаарлагдмал нөөцөөр хэрхэн хангах тухай
- B. Хязгаарлагдмал хэрэгцээг хязгааргүй нөөцөөр хэрхэн хангах тухай
- C. Юу үйлдвэрлэх, яаж үйлдвэрлэх, хэнд үйлдвэрлэх тухай асуудал
- D. Үйлдвэрлэл, хуваарилах, хэрэглэх, арилжах, солилцох харилцаа
18. Компани хэлбэрээр зохион байгуулагдсан аж ахуйн нэгжүүдийн ашгийг хэн хүртдэг вэ?
- A. Өмчлөгч эзэн                      B. Гишүүд                      C. Удирдлагууд                      D.Хувьцаа эзэмшигчид
19. Эдийн засгийн шинжлэх ухааныг судалгааны хамрах хүрээгээр хэрхэн ангилдаг вэ?
- A. Хязгааргүй хэрэгцээг хязгаарлагдмал нөөцөөр хэрхэн хангах тухай
- B. Хязгаарлагдмал хэрэгцээг хязгааргүй нөөцөөр хэрхэн хангах тухай
- C. Юу үйлдвэрлэх, яаж үйлдвэрлэх, хэнд үйлдвэрлэх тухай асуудал
- D. Макро эдийн засгийн ухаан, микро эдийн засгийн ухаан
20. Нийт эрэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдэд хамааралгүй өгөгдлийг тэмдэглэнэ үү.
- A. Төрийн худалдан авалтын зардал                      B. Гадаадын хэрэглэгчийн зардал
- C. Дотоод хөрөнгө оруулалтын зардал                      D. Нийлүүлэлтийн зардал
21. Монгол улсын иргэн Солонгос улсад аж ахуй нэгжтэй бол түүний үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн үйлчилгээний үнийн эцсийн дүн хэрхэн тооцогдох вэ?
- A.Солонгос улсын ҮНБ                      B.Монгол улсын ДНБ
- C.Солонгос улсын ҮНБ, Монгол улсын ДНБ
- D.Солонгос улсын ДНБ, Япон ҮНБ                      E.Монгол улсын ҮНБ, Солонгос улсын ДНБ
- Улс төр :
22. "Ардчилал бол хамгийн муу засаглалын хэлбэр, гэхдээ хүн төрөлхтөн үүнээс илүүг харахан олоогүй байна" гэж хэн хэлсэн бэ?
- A. У Черчилль                      B. А.Линкольн                      C. Г.Алмонд                      D. Д.Истон                      E. К.Маркс
23. Олон түмэн өөрөө өөрийгөө удирдах хэлбэр бөгөөд Эртний Грект иргэн бүрийг төрийг удирдах хэрэгт оролцуулдаг ардчилсан төрийн хэлбэр анх үүссэн юм. Ардчиллын аль хэлбэрийн тухай өгүүлсэн байна вэ?
- A. Төлөөллийн ардчилал                      B. Шууд ардчилал                      C. Элитийн ардчилал

Е. Эртний ардчилал

Д. Олон ургальч ардчилал

24. Ардчилсан нийгэм нь иргэдийн эрхийг хамгаалах, үйлчлэх анхдагч үүргээ сонгуульт албан тушаалтан, төрийн албан хаагчдын эрх мэдлэг урвуулан хэтрүүлэн ашиглах явдлаас урдчилан сэргийлэх боломж олгодог ардчиллын үнэт зүйлс аль нь вэ?

А. Иргэдийн улс төрийн оролцоо

В. Нийтэд тайлагнах, ил тод байх ёс

С. Хуулийн засаглал

Д. Эрх мэдлээ хэтрүүлэхэд хяналт тавих

Е. Тогтмол чөлөөт шударга сонгууль

25. "Улсын ба хөдөлмөрчдийн олон түмний бусад бүх байгууллагын манлайлал бөгөөд жолоодогч МАХН мөн" гэж хэдэн оны үндсэн хуулинд заасан бэ?

А. 1924.11.26

В. 1940.06.30

С. 1960.07.06

Д. 1992.01.13

Е. Аль нь ч

биш

26. 1990 оноос өмнөх төрийн бодлогын ялгааг олно уу.

А. Хувийн өмчтэй байхыг зөвшөөрч, түүнийхээ үр шимээр амьдрах

В. Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй

С. Улс түмний харилцан ашигтай хамтын ажиллагааг эрхэмлэх

Д. Үг хэлэх, хэвлэн нийтлэх, эвлэлдэн нэгдэх, эрх ашгаа хамгаалах, эрх чөлөөнд хэм хэмжээ тогоох

Е. Хуульд захирагдан амьдрах

27. Америкийн улс төр судлаач Д.Истоны боловсруулсан онол аль нь вэ?

А. Тэрээр дээд засаглал нь хоорондоо харилцан уялдаатай, харилцан уг хамаарах гурван улс төрийн байгууллагаас бүрдэх ёстой гэж үзсэн

В. Хэрэв хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийг нэг этгээдэд буюу байгууллагад нэгтгэвэл, эрх чөлөө хэрэгжихгүй бөгөөд эзэн хаан болон хууль тогтоогчид дарангуйлагч хуулийг тогтоож, хэрэгжүүлэх аюулд тулгарна

С. Улс төр бол нийгэм дэх үнэт зүйлсийг эрх мэдэлд тулгуурлан байршуулах үйл явдал юм

Д. Улс төр бол эрх мэдэлд хүрэх эрх мэдлийг тогтоон барьж байх ба ашиг хонжоо олохын тулд эрх мэдлийг ашиглан албадлагын арга хэрэгслийн цогц юм гэж тодорхойлсон

Е. Ардчиллын үнэт зүйлсийг нарийвчлан судалж, ойлголтыг цэгцэлж өгсөн эрдэмтэн

28. "Гадаад бодлогын шийдвэр нь наймааны шинжтэй байна" гэж үздэг онол аль нь вэ?

А. Загвар А С. Загвар В В. Загвар Б Д. Загвар Г Е. Дээрх бүгд

29. Улс оролцогчдыг их гүрэн, дунд улс, бага улс гэж ангилах гол шалгуур аль нь вэ?

А. Эдийн засгийн өсөлт болон бүх нийтийн боловсролын ялгаагаар нь

В. Улс орон бур аюулгүй байдлаа хангах чадвар, боломжоор нь

С. Улс орнуудын нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээгээр нь

Д. "Фрийдом хаус" ТББ-аас гаргасан эрх чөлөөт байдлын үнэлгээгээр нь

Е. Улс төрийн дэглэмийн хэлбэрээр нь

30. Монгол улсын олон улсын харилцаанд оролцох үүүргийг аль өгөгдөл харуулж байна вэ?

А. Монгол улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж, энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна

В. Монгол улс бусад улсын улс төр, эдийн засаг, соёлын хүч чадавхи, үйл ажиллагааг верийн боломжоор хянах, үнэлэх явдал юм

С. Олон улсын улст төр, эрх зүй, эдийн засаг, соёлын зэрэг олон талт харилцаанд гадаад бодлогоороо дамжуулан оролцох үйл ажиллагааны цар хүрээ, нөөцөөллөөр тодорхойлогдоно

Д. Олон улсын харилцаанд улс төр, эрх зүй, эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан, хүмүүнлэгийн гэсэн үйл ажиллагааны чиглэлээр оролцдог

Е. Гадаад харилцаа хамтын ажиллагаандаа нөөц бололцоог бүрэн дайчлан зохион байгуулах явдал юм

### Хоёрдугаар хэсэг

2.1 Дараах өгөгдлүүдийг зөв харгалзуулна уу?

1	Нийгэмш илт	А	Тусгай аргуудыг ашиглан нийгмийн ертөнцийн тухай үнэн бодит, шинэ зүйлийг илрүүлэх цогц үйл ажиллагаа.
---	-------------	---	--

2	Нийгмийн судалгаа	B	Гажуудлаас урьдчилан сэргийлэх, арилгах үүднээс нийгмийн гишүүдийн зүгээс гажуудагчийг шийтгэх, засан хүмүүжүүлэх зэрэг хэлбэрээр авч буй арга хэмжээ буюу санкциудын цогц.
3	Нийгмийн гажуудал	C	Нийгэм, нийгмийн бүлгийн олонх гишүүдийн хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, хүлээлттэй үл нийцэх төлөв
4	Бэлгэ тэмдэг	D	Соёл бол хүн бодол санаагаа ямар нэг тэмдэгтэд төлөөлөл, бэлгэдэл болгон шингээж буй хэрэг юм

## 2.2 Соёлыг бүрдүүлэгч элементүүдийг зөв харгалзуулна уу

B	Хэл	1	Хүмүүсийн мэддэг баримт, туршлага, үнэт зүйлсийг хэлнэ.
C	Үнэлэмж	2	Хүмүүсийн зан төлвийг зохицуулдаг дэг журам, хууль дүрэм, ёс заншил зэргийг бүхэлд нь хэлнэ.
D	Хэм хэмжээ	3	Юуг зөв гэж хүлээн завшөөрөх, бас юуг буруу, зохисгүй гэж үзэх талаар нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн эрхэм чанаруудыг хэлнэ.
E	Мэдлэг	4	Хүний оюуны ертөнцийг илэрхийлэгч, хадгалагч, дамжуулагч арга хэрэгсэл.

## 2.3 Зөв харгалзуулна уу?

a	Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгох нөхцөл	1	Даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлийг 3болон түүнээс дээш сарын хугацаагаар төлсөн тохиолдолд
b	Жирэмсэн болон амаржсаны тэтгэмж олгох нөхцөл	2	Даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлийг ажилгүй болхоосоо өмнө 24 сараас доошгүй хугацаанд үүнээс сүүлийн 9сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд олгоно
d	Ажилгүйдлын тэтгэмж олгох нөхцөл	3	Нийгмийн даатгалын шимтгэлийг 12сар түүний сүүлийн 6 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд олгоно
e	Нийгмийн даатгалын сан	4	Тэтгэвэр тэтгэмж олгоно

## 2.4 Ардчилалын үнэт зүйлсийг зөв харгалзуулна уу?

1	Хуулийн засаглал	A	Иргэнийхээ хувьд хүлээж байгаа ёс суртахууны үүрэг
2	Боловсрол	E	Арьс өнгө, шашин шүтлэг, үндэс угсаа, хүйс, үзэл бодлоор ялгаварлахгүй байх
3	Иргэдийн улс төрийн оролцоо	C	хаан, ерөнхийлөгч, сайд хэн нь ч хуулиас дээгүүр эрх эдлэхгүй
4	Тэгш эрх	D	Боловсролтой иргэд нь ардчлалыг хөгжүүлэх гол хөшүүрэг

## 2.5 Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу?

1	Хэвийн инфляци	E	Тухайн нөхцөл дахь барааны хомсдол, хүн амын орлогын дутагдал зэргээс үүдэн гардаг инфляци
2	Зохисгүй инфляци	B	Үнэ огцом түргэн бөгөөд жигд бусаар дээшилж байгаа нөхцлийн инфляци (орон)
3	Мөлхөө инфляци	C	Үнэ аажмаар хэлбэрэлтгүй өсөж буй инфляци (1 орон)
4	Цогио инфляци	D	Төрийн мөнгөний бодлогоос хамаарч үүдэн гардаг инфляци

## 2.6 Дараах өгөгдлүүдийг зөв харгалзуулна уу?

1	Шилжих төлбөр	A	Өнөөгийн үнээр тооцсон ДНБ
2	Үндэсний нийт бүтээгдэхүүн	B	Тогтмол үнээр тооцсон ДНБ
3	Бодит дотоодын нийт бүтээгдэхүүн	C	Дотоод болон хилийн чанад дахь монголын хөрөнгө оруулалттай ААН-үүдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг
4	Нэрлэсэн ДНБ	D	Төрөөс зарим иргэд, гэр бүлд үзүүлдэг буцалтгүй тусламжийн хэлбэртэй төлбөрүүд

## 2.7 Зөв тохируулна уу ?

1	Робер даль	a	Улс төр бол нийгэм дэх үнэт зүйлсийг эрх мэдэлд тулгуурлан хуваарилан байршуулах үйл явдал юм.
2	Николь Ди Бернарда Макиавелли	b	Улс төр бол эрх мэдэлд хүрэх, эрх мэдлийг тогтоон барьж байх ба ашиг хонжоо олохын тулд эрх мэдлийг ашиглан албадлагын арга хэрэгслийн цогц юм.
3	Д.Истон	c	Ардчиллын үнэт зүйлсийг нарийвчлан судалж ойлголтыг цэгцэлж өгсөн эрдэмтэн.
4	У.Черчилль	d	"Ардчилал бол хамгийн муу засаглалын хэлбэр, гэхдээ хүн төрөлхтөн үүнээс илүүг хараахан олоогүй байна" гэж хэн хэлсэн бэ?

## 2.8 Зөв харгалзуулна уу ?

1	2014онд Монгол улс БНМАУ	A	Улаанбаатар тунхаглал
2	2011онд Монгол улс БНМАУ	B	Москвагийн тунхаглал
3	2006 онд Монгол,ОХУ-ын хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай	C	Стратегийн түншлэлийн гэрээ байгуулсан
4	2000онд ОХУ-ын ерөнхийлөгч В.В.Путин Монгол улсад айлчилахдаа	E	Монгол Оросын хоорондын байгуулсан "Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ

## 2.9

### Зөв харгалзуулна уу ?

1	2014онд Монгол улс БНМАУ	A	Улаанбаатар тунхаглал
2	2011онд Монгол улс БНМАУ	B	Москвагийн тунхаглал
3	2006 онд Монгол,ОХУ-ын хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай	C	Иж бүрэн Стратегийн түншлэлийн гэрээ байгуулсан
4	2000онд ОХУ-ын ерөнхийлөгч В.В.Путин Монгол улсад айлчилахдаа	D	Стратегийн түншлэлийн гэрээ байгуулсан

## 2.10

1	1993 онд Монгол улсын ерөнхийлөгч П.Очирбат ОХУ-д хийсэн төрийн айлчилал	A	Улаанбаатар тунхаглал
2	2000онд ОХУ-ын ерөнхийлөгч В.В.Путин Монгол улсад айлчилахдаа	B	Москвагийн тунхаглал
3	2006 онд Монгол,ОХУ-ын хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай	C	Стратегийн түншлэлийн гэрээ байгуулсан
4	2011онд Монгол улс БНМАУ	D	Монгол Оросын хоорондын байгуулсан "Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ



ЗАХИРАЛ: **Ж.БОЛОРМАА**

**5 ДУГААР СУРГУУЛИЙН “НИЙГЭМ СУДАЛ” ХИЧЭЭЛИЙН 10-Р АНГИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ЖИШИГ ДААЛГАВАР**

Нийгмийн ухаан 10-р анги дэвших шалгалт Анги ..... Нэр ..... Б хувилбар

**1-Р ХЭСЭГ ДААЛГАВАР**

1. "Нийгмийн бүтэц гэдэг нь нийгмийн хэсэг, элементүүдийн хооронд бэхжсэн тогтвортой харилцаа холбоог хэлнэ" гэж хэн хэлсэн бэ?  
А.Э.Дюркгейм В.К.Маркс С.Ж.Г.Мид D. Л.Толстой е. Занден  
..... эзэлж буй байр сууриас үүдэн бий болж, заавал биелүүлэх ёстой, хэм. хэмжээлэг шинжтэй зан үйлүүдийн цогц.
2. Хүйс үндэс угсаа зэрэг байр суурь нь:  
А. Төрөлх В. Олдмол С. Мастер d. Үндсэн е. Аль нь ч биш
3. Багш хүн албан үүргээ гүйцэтгэхийн тулд гэр бүлийн зарим үүргээ биелүүлж чадахгүйд хүрддэг. Үүнийг .....гэнэ.  
А. Үүргийн зөрчил В. Үүрэг С. Зөрчил маргаан D. Зөрчил
4. Өөрийнхөө санаа бодлыг илэрхийлэхдээ хэрэглэж буй бэлгэ тэмдэг, худалдаа арилжаандаа хэрэглэж буй мөнгөний тогтолцоо, мэргэжлийн зүгээс дагаж мөрдөх горим журам гэх мэт зүйлс надаас, миний хэрэглээнээс үл хамааран оршдог" гэсэн Э.Дюркгеймийн тайлбар нь онолын аль хандлагад хамаарах вэ?  
А. Марксизм В. Бэлгэ тэмдгийн харилцан үйлдлийн онол С. Бүтэц-үүргийн онол D. Дээрх бүгд зөв
5. "Тодорхой бүлгийн гишүүдэд байдаг үнэт зүйлс, тэдгээрийг дагаж мөрддөг хэм хэмжээ болон материаллаг баялгийг багтаасан цогц ойлголтыг соёл гэдэг" нь аль эрдэмтний тодорхойлолт вэ?  
А. А. Гидденс В. Р. Бенедикт С. Э.Тайлор D. Э. Кассирер Е. С. Дулам
6. .... хуулинд монгол хэл, бичиг үсгээ хамгаалах, хөгжүүлэх талаар идэвх санаачилга гаргасан иргэн, хуулийн этгээдэд 4 жил тутамд "Монгол улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит шагнал олгоно" гэж заажээ.  
А. 2008 он, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль В. 2001 он, Үндэсний Аюулгүй байдлын тухай  
С. 2008 он, Монгол улсыг хөгжүүлэх сангаас хөрөнгө зарцуулах тухай D. 2015 он, Монгол хэлний тухай  
E. 2014 он, Номийн сангийн тухай
7. Монголчуудыг ямар үндэслэлээр "Туршлагын шинжтэй эрдэм ухаантай" ард түмэн гэдэг вэ?  
А. Тэнгэр унших эрдэм В. Дөрвөн улиралд малаа маллах С. Дөрвөн улиралд мал үржүүлэх  
D. Бэлчээрийн өвс ургамлын ая тусыг таних E. Дээрх бүгд
8. "Соёл" хэмээх үзэгдлийн талаарх тодорхойлолтын тоо хагас мянгад хүрч байна. Соёлын тухай тодорхойлолтуудаас Э.Тайлорын тодорхойлолтыг сонгоно уу.  
А. Соёл бол хүмүүсийн хүмүүсийн аж төрөх ёс В. Соёл бол харилцааны арга, хэлбэр  
С. Соёл бол хүний бүтээсэн зүйлс, хоёрдогч байгаль D. Соёл бол нийгмийн хэм хэмжээ.  
E. Соёл бол хүн нийгмийн гишүүн гэдгээ ойлгох чадвар.
9. "Хүний нэр төр алдар хүнд эрх хууль ёсны ашиг сонирхлыг хүндэгэх иргэний үндсэн үүрэг" болохыг аль хуулинд заасан байдаг вэ?  
А. Монгол улсын үндсэн хууль В. Зөрчлийн тухай хууль С. Эрүүгийн хууль  
D. Хүний эрхийн түгээмэл тунхаглал E. Хүний эрхийн конвенц
10. Хүний эрхэм чанарын үндсэн шинжүүдээс илүүцийг ол.  
А. Хүний эрхэм чанар нь хүн бүрд адилхан байдаг В. хүнээс хүний эрхэм чанарыг салгаж болдоггүй  
С. Хүний эрхэм чанарт халдаж болохгүй D. Хүний эрхэм чанар нь үл хэмжигдэх хүний үнэт зүйл E. Хүний эрхэм чанар нь төрийн зохицуулалтаар олгогддог
11. Захиргааны шийдвэр буюу ..... гэж нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор захиргааны байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэр юм.  
А. Захирамж В. Акт С. Гомдол D. Гэрээ E. Тушаал
12. Иргэний эрх зүйн харилцааны бүдэл хэсгийг олно уу.  
А. Төрөлх ба зохиомол В. Төрөлх ба олдмол С. Субъект объект үүрэг D. Субъект Объект  
E. Субъект Объект Агуулга
13. 7-14 насны хүүхэд эрх зүйн аль чадамжид хамаарах вэ?  
А. Эрх зүйн бүрэн чадамжтай В. Эрх зүйн бүрэн бус чадамжтай С. Эрх зүйн заримдаг чадамжтай  
D. Эх зүйн чадамжтай
14. Мартин Лютер Кингийн илтгэлд хүний эрхийн мар асуудалыг хөндсөн бэ? Эх сурвалж: 1963 онд Вашингтонд болсон иргэдийн эрхийн төлөө жагсаалын үеэр Мартин Лютер Кинг "надад мөрөөдөл бий" илтгэлдээ: Миний 4н хүүхэд

нэгэн өдөр арьсны өнгөөрөө биш өөрийн чадвар чадлаараа үнэлэгдэх тийм улсад амьдраасай гэж би мөрөөддөг” гэж хэлсэн.

А.Тэгш байдлыг хангах В.Ялгаварлан гадуурхахгүй байх С.Хуваагдашгүй байх D.Үнэ цэнэ нэр төтэй байх E.Харилцан хамааралтай байх

15.ДНБ-ийг орлогоор тооцох үзүүлэлтэд хамаарагдахгүй өгөгдлийг тэмдэглэнэ үү.

А. Цалингийн орлого В. Түрээсийн орлого С. Шууд татварын орлого D. Аж ахуйн нэгжийн ашиг

16.Нийгмийн харилцааны явцад хөдөлмөрийн хуваарийн өөрчлөлттэй холбоотойгоор үүсэн бий болдог ажилгүйдлийн хэлбэрийг тэмдэглэнэ үү.

А. Мөчлөгийн В. Бүтцийн С. Шилжилтийн D. Улирлын

17.Эдийн засгийн тогтолцооны хэв маягуудад аль нь хамааралгүй вэ?

А. Зах зээлийн В. Төлөвлөгөөт С. Уламжлалт D. Бүх нийтийн

18.Нэг хүний эзэмшлийн аж ахуйн нэгжийн алдагдлыг хэн хүлээдэг вэ?

А. Өмчлөгч эзэн В. Гишүүд С. Удирдлагууд D.Хувьцаа эзэмшигчид

19.Эдийн засгийн үйл ажиллагааг тодорхойлно уу.

А. Хязгааргүй хэрэгцээг хязгаарлагдмал нөөцөөр хэрхэн хангах тухай

В. Хязгаарлагдмал хэрэгцээг хязгааргүй нөөцөөр хэрхэн хангах тухай

С. Юу үйлдвэрлэх, яаж үйлдвэрлэх, хэнд үйлдвэрлэх тухай асуудал

D. Үйлдвэрлэл, хуваарилах, хэрэглэх, арилжаа, солилцоо харилцаа

20.Засгийн газрын хөтөлбөр боловсруулж, түүнийг хэрэгжүүлэхэд зориулж төр зардлаа ихэсгэдэг. Энэ нь төрийн эдийн засгийн ямар бодлого вэ?

А. Төрийн сангийн бодлого В. Мөнгө зээлийн бодлого С. Гадаад худалдааны бодлого D. Татварын бодлого

21.Ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг зөврийн компьютерээр хангасан.Энэ нь ДНБ-ий аль зардалд хамаарах вэ?

А.Өрхийн хэрэглээний зардал В.Аж ахуй нэгжийн зардал С.Төрийн зардал D.Гадаадын хэрэглэгчийн зардал E.Боловсролын зардал

22.Цэгийн оронд нөхнө уу. Ардчилал гэдэг нь эртний Грек хэлний ..... гэсэн үгнээс гаралтай.

А. Oikos, Nomos С. Byuro, Cratos В. Demos, Cratos D. Tekhno, Cratos E. Human rig

23.Ардчилал нь ард түмнээс сонгогдсон, ард түмний төлөө, ард түмний өөрсдийнх нь засаглал юм” гэж хэн хэлсэн бэ?

А. У.Черчилль В. Н. Макиавелли С. Ж.Локк D. А.Линкольн E. Д.Истон

24. БНМАУ-ын төрийн байгууллыг хөгжүүлэн бэхжүүлэх зорилгоор иргэдэд үг хэлэх, хэвлэн нийтэх, хурал цуглаан хийх, жагсаал ёслол үйлдэх эрх чөлөөг хуулиар батлан олгосон. Энэхүү заалт нь аль хуулинд байдаг вэ?

А. 1924 оны үндсэн хуулинд В. 1940 оны үндсэн хуулинд

С. 1960 оны үндсэн хуулинд D. 1992 оны үндсэн хуулинд

E. 2020 оны үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр

25. Ямар ч иргэнийг ижил боломжтой байлгаж, арьс өнгө, шашин шүтлэг үндэс угсаа, хүйс, үзэлбодлоо ялгаварлахгүй байх нь” ардчиллын аль үнэт зүйлс вэ?

А. Хүний эрх, эрх чөлөө В. Иргэдийн улс төрийн оролцоо С. Тэгш эрх D. Ил тод байх E. Хуулийн засаглал

26.1990 оны дараах төрийн бодлогод үлхамаарах өгөгдлийг сонгоно уу.

А. Хувийн өмчтэй байхыг зөвшөөрөх В. Сонгох, сонгогдох ардчилсан эрхээ эдлэх

С. Олон ургалч үзлийг хүлээн зөвшөөрөх D. Шашин шүтэх эс шүтэх эрх чөлөөтэй

E. Хүний эрхийн түгээмэл зарчмуудыг ёс төдий тунхаглах

27. "Сэргэн мандалтын үеийн туухч, улс төрч орчин үеийн улс төрийн шинжлэх хааныг үндэслэгч Николь Ди Бернарда Макиавелли"-ийн онол аль нь вэ?

А. Тэрээр дээд засаглал нь хоорондоо харилцан уялдаатай, харилцан үл хамаарах гурван улс төрийн байгууллагаас бүрдэх ёстой гэж үзсэн

В. Хэрэв хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийг нэг этгээдэд буюу байгууллагад нэгтгэвэл, эрх чөлөө хэрэгжихгүй бөгөөд эзэн хаан болон хууль тогтоогчид дарангуйлагч хуулийг тогтоож, хэрэгжүүлэх аюулд тулгарна

С. Улс төр бол нийгэм дэх үнэт зүйлсийг эрх мэдэлд тулгуурлан байршуулах үйл явдал юм

D. Улс төр бол эрх мэдэлд хүрэх эрх мэдлийг тогтоон барьж байх ба ашиг

хонжоо олохын тулд эрх мэдлийг ашиглан албадлагын арга хэрэгслийн цогц юм гэж тодорхойлсон

E.Ардчиллын үнэт зүйлсийг

28. Дэлхийн улс ба улс бус оролцогчид хоорондын олон талт харилцаа, тэдний гадаад бодлого, үйл ажиллагааг судалдаг нийгмийн шинжлэх ухааны салбар шинжлэх ухааныг хэрхэн нэрлэдэг вэ?

А. Социологи В. Олон улсын харилцаа С. Улс төр D. Эдийн засаг E. Эрх зүй

29. Улс оролцогчийг ямар хэлбэрээр хүлээн зөвшөөрдөг вэ?

А. Де-Факто, Де-Юре В. Их гуран, дунд улс, Сонгодог бага улс С. Бүрэн Тусгаар тогтносон, Хараахан Тусгаар тогтноогүй D. Колони улс ба Эзэн улс E. Их гуран, дунд улс, бага улс

30. Олон улсын төрийн бус байгууллагуудын онцлогийг дурдахдаа алдаатай зүйл оруулсан бол аль нь вэ?

А. Олон улсын засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээрээр үүсгэн байгуулагдаагүй

В. Улс орны асуудалд түлхүү анхаардаг С. Ашгийн бус

D. Хоёроос дээш улсаас хандив авч, үйл ажиллагаа явуулдаг

E. Голчлон хумууллагийн болон шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг

## 2-Р ХЭСЭГ ДААЛГАВАР

2.1 Нийгмийн институтын чиг үүргийг зөв харгалзуулаарай.

1	Ил чиг үүрэг	A	Үйлдэгч нь урьдчилан тооцоолоогүйгээр бий болсон үр дагавар
2	Далд чиг үүрэг	B	Тухайн үйлдлийг гүйцэтгэгчээс мэдэж тооцоолсон үр дагавар
3	Сөрөг чиг үүрэг	C	Нийгмийн үйлдэгчдийн тодорхой үр дагаварт хүрэхээр зорьж хийсэн үйлдэл нь зорьсныхоо эсрэг үр дагаварт хүрэх.
4	Чиг үүрэг	D	Эзэлж буй байр сууриас үүдэн заавал биелүүлэх ёстой хэм хэмжээний цогц

2.2 .Зөв харгалзуулна уу ?

1	Үнэлэмж хэм хэмжээ	A	Нийгэмд үйлчилж байдаг хэм хэмжээг эзэмшсэнээр хүмүүс амьдралын чиг баримжаагаа олж авдаг.
2	Үйл ажиллагааны чиг үүрэг	B	Соёл нь нийтлэг итгэл үнэмшил, үнэлэмжийн тогтолцоог бүрдүүлэх замаар нийгмийг нэгтгэдэг
3	Бэлгэдэлийн чиг үүрэг	C	Соёлын үзэгдлүүд тэмдгийн хэлбэрээр оршдог. Тэмдгийн түгээмэл хэлбэр нь хэл юм
4	Нэгтгэн зохицуулах	D	Нийгэм-соёлын уламжлалыг өвлүүлэх нь нийгмийн оршихуйн үндэс юм.

2.3 Соёлын тухай тодорхойлолтыг зөв харгалзуулна уу.

1	A.Гидденс	A	"Зөгий, шоргоолжний эд эсэнд нь шингэсэн үйлдэл хийх чадвар байдаг шиг хүнд төрөлхөөс заяадаггүй, ахмад үеэсээ залуу үе нь зориуд сурч мэдэх, өвлөх ёстой үйлдэл хийх чадвар байдгийг соёл гэж тэмдэглэдэг.
2	P.Бенедикт	B	"Тодорхой бүлгийн гишүүдэд байдаг үнэт зүйлс, тэдгээрийг дагаж мөрддөг хэм хэмжээ болон материаллаг баялгийг багтаадаг цогц ойлголтыг соёл гэдэг"
3	Э.Тайлор	C	"Соёл бол янз бүрийн бэлгэ тэмдгүүдийн (хэл, бичгийн хэл, урлаг, шинжлэх ухаан гэх мэт) нэгдэл мөн"
4	Э.Кассирер	D	"Соёл нь нийгмийн гишүүн болохынхоо хувьд эзэмшдэг мэдлэг, итгэл үнэмшил, урлаг, ёс суртахуун, хууль зан заншил болон бусад чадвар дадлуудыг багтаасан цагц бүхэл юм"

2.4 Соёлыг бүрдүүлэгч элементүүдийг зөв харгалзуулна уу

1	Хэл	A	Хүмүүсийн мэддэг баримт, туршлага, үнэт зүйлсийг хэлнэ.
2	Үнэлэмж	B	Хүмүүсийн зан төлөвийг зохицуулдаг дэг журам, хууль дүрэм, ёс заншил зэргийг бүхэлд нь хэлнэ.
3	Хэм хэмжээ	C	Юуг зөв гэж хүлээн завшөөрөх, бас юуг буруу, зохисгүй гэж үзэх талаар нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн эрхэм чанаруудыг хэлнэ.
4	Мэдлэг	D	Хүний оюуны ертөнцийг илэрхийлэгч, хадгалагч, дамжуулагч арга хэрэгсэл.

2.5 Зөв харгалзуулна уу ?

1	Үндэсний нийт бүтээгдэхүүн	A	Тогтмол буюу зэрэгцүүлэн тогтоосон дотоодын нийт бүтээгдэхүүнийг хэлнэ
2	Бодит дотоодын нийт бүтээгдэхүүн	B	Бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох зорилгоор үйлдвэрлэлд хэрэглэсэн бүх бараа үйлчилгээний өртөгийг хэлнэ
3	Нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн	C	Тодорхой хугацаанд тухайн улсын хил доторх дотоод гадаад ЭЗ-н харьяатуудын шинээр үйлдвэрлэн бий болгосон нэмэгдэл өртөгийн нийлбэр дүнг хэлнэ
4	Нэг хүнд ноогдох нийт бүтээгдэхүүн	D	Өнөөгийн үнээр тоон тооцсон ДНБ-г хэлнэ

2.6 Хүний эрхийн түгээмэл тунхаглалд тусгагдсан хүний эрхийн суурь зарчмуудыг зөв харгалзуулна уу.

1	Тэгш байдлыг хангах	A	Арьс өнгө шашин шүтлэг үзэл бодол нийгмийн гарал өмч хөрөнгөөс үл хамаарах
2	Ялгаварлан гадуурхахгүй байх	B	Төр хүний эрхийг хүндэтгэх хамгаалах
3	Хуваагдашгүй байх	C	Иргэний улс төрийн нийгэм эдийн засаг соёлын эрх
4	Төртэй хариуцлага тооцох	D	Хүн бүр ижил үнэ цэнэтэй



2.7 Ардчилалын үнэт зүйлсийг зөв харгалзуулна уу?

1	Хүний эрх чөлөө	A	Арьс өнгө, шашин шүтлэг, үндэс угсаа, хүйс, үзэл бодлоор ялгаварлахгүй байх
2	боловсрол	B	Иргэнийхээ хувьд хүлээж байгаа ёс суртахууны үүрэг
3	Тэгш эрх	C	Боловсролтой иргэд нь ардчлалыг хөгжүүлэх гол хөшүүрэг
4	Иргэдийн улс төрийн оролцоо	D	Хүн бүр эрх тэгш чөлөөтэй байх эрхтэй

2.8 Зөв харгалзуулна уу ?

1	Робер даль	A	Улс төр бол нийгэм дэх үнэт зүйлсийг эрх мэдэлд тулгуурлан хуваарилан байршуулах
2	Николь Ди Бернарда макиавелли	B	Улс төр бол эрх мэдэлд хүрэх, эрх мэдлийг тогтоон барьж байх ба ашиг хонжоо олохы мэдлийг ашиглан албадлагын арга хэрэгслийн цогц юм.
3	Д.Истон	C	Ардчллын үнэт зүйлсийг нарийвчлан судалж ойлголтыг цэгцэлж өгсөн эрдэмтэн.
4	Э. Кассирер	D	Соёл нь янз бүлэг тэмдэгүүдийн нэгдэл мөн.

2.9 Зөв харгалзуулна уу ?

1	1993 онд Монгол улсын ерөнхийлөгч П.Очирбат ОХУ-д хийсэн төрийн айлчилал	A	Улаанбаатар тунхаглал
2	2000онд ОХУ-ын ерөнхийлөгч В.В.Путин Монгол улсад айлчилахдаа	B	Москвагийн тунхаглал
3	2006 онд Монгол,ОХУ-ын хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай	C	Стратегийн түншлэлийн гэрээ байгуулсан
4	2011онд Монгол улс БНМАУ	D	Монгол Оросын хоорондын байгуулсан "Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ

2.10 Зөв харгалзуулна уу ?

1	2014онд Монгол улс БНМАУ	A	Улаанбаатар тунхаглал
2	2011онд Монгол улс БНМАУ	B	Москвагийн тунхаглал
3	2006 онд Монгол,ОХУ-ын хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай	C	Иж бүрэн Стратегийн түншлэлийн гэрээ байгуулсан
4	2000онд ОХУ-ын ерөнхийлөгч В.В.Путин Монгол улсад айлчилахдаа	D	Стратегийн түншлэлийн гэрээ байгуулсан